



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын
дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Ц.Цогт даргалж, Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, Ц.Оч, Т.Өсөхбаяр, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийж,

Иргэний зориг ногоон намын 1)2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын “Намын даргаар сонгогдсоныг болон дүрмийн өөрчлөлтийг шинэчлэн баталсныг бүртгүүлэх” тухай 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн өргөдөл, 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн тайлбар; 2)“2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаар намын дүрмийг шинэчлэн баталсныг бүртгүүлэх” тухай намын дарга Б.Батбаатарын 2026 оны 04 дүгээр сарын 29, 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар тус тус хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Иргэний зориг ногоон намын Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдоос “... анхан болон дунд шатны байгууллага, гишүүдээс ирүүлсэн албан шаардлагуудын дагуу Удирдлагуудын хурлаас шийдвэр гарч, намын гишүүдийн “Онц Их хурал”-ыг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зарлан хуралдууллаа. Онц Их хурлаар намын удирдлагын үйл ажиллагаанд намын дүрэм, дотоод журам, намын гишүүдийн эрх ашиг, эв нэгдлийг ноцтой зөрчсөн үйлдэл гаргасан үндэслэлээр Б.Батбаатарыг намын даргын сонгуульт албан тушаалаас огцруулж, Р.Батболдыг ИЗНН-ын даргаар сонгогдсоныг, намын дүрмийн өөрчлөлтийг шинэ хуульд нийцүүлэн тус тус баталсан. Дүрэмд оруулсан өөрчлөлт, намын даргын өөрчлөлтийг бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 618 хуудас баримт бичиг, зөөврийн дискийн хамт 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Дээрх өргөдөл, баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.5-д заасны дагуу шалгаж, 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр сонсох ажиллагаа хийсэн ба үүний дараа 2026

оны 05 дугаар сарын 19-ний өдөр хариу тайлбар, 160 хуудас баримт бичиг, 134 хуудас бүхий 369 гишүүний батлахын хамт нэмэлтээр ирүүлснийг шалгасан.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаас Иргэний зориг ногоон намаас ирүүлсэн өргөдөл, намын дүрмийг бүртгэх эсэх асуудлыг хэлэлцэх хуралдааныг хойшлуулсантай холбогдуулан 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр тайлбар, 9 хуудас баримт ирүүлснийг мөн нэмж шалгасан, уг тайлбарт "... намын ахмад хорооны дарга Л.Дашнямын санаачилгаар 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр талууд (Р.Батболд, М.Амартунгалаг, Б.Батбаатар, Я.Санжмятав, н.Алтан-Оч) уулзаж, санал солилцсоноор Б.Батбаатар нь төлөөллийн төв байгууллага дүрмийн бус, түүнээс зарласан Их хурал болон гарсан шийдвэрүүд дүрмийн болон эрх зүйн чадамжгүй, түүнчлэн энэхүү зөрчлийг арилгах зөвтгөх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн нь Онц Их хурлыг бүхэлд нь дэмжсэнд тооцсон болно, ... Иймд холбогдох хуульд нийцүүлэн "2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас намын даргаар Б.Батболдыг сонгосныг болон дүрмийн өөрчлөлтийг шинэчлэн баталсныг бүртгүүлэх" тухай Р.Батболдын 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын дээд шүүхэд хүргүүлсэн өргөдлийг шийдвэрлэхийг" хүссэн агуулгатай байна.

Хоёр. Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатараас "... намын ээлжит бус XIII Их хурал 2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хуралдаж, намын дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан тул бүртгэж өгнө үү" гэсэн өргөдлийг 311 хуудас баримт бичиг, 61 хуудас бүхий 181 гишүүний үнэмлэх (батлах), зөөврийн дискийн хамт 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Дээрх өргөдөл, баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.5-д заасны дагуу шалгаж, 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр сонсох ажиллагаа хийсэн ба үүний дараа 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хариу тайлбар, 384 хуудас баримт бичиг, 178 гишүүний анкет, зөөврийн диск зэргийг нэмэлтээр ирүүлснийг шалгасан.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаас Иргэний зориг ногоон намаас ирүүлсэн өргөдөл, намын дүрмийг бүртгэх эсэх асуудлыг хэлэлцэх хуралдааныг хойшлуулсантай холбогдуулан "... Дүрмийн хороо намын дотоод маргааныг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн намын ээлжит бус XIII Их хурлаар батлагдсан дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх нэг өргөдлийг холбогдох баримтын хамт хүргүүлж байна, энэ нь намын цорын ганц хууль ёсны, нэгдсэн өргөдөл мөн ..." гэх агуулга бүхий өргөдлийг 300 хуудас баримт бичиг, 1 ширхэг зөөврийн дискийн хамт 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр ирүүлснийг мөн шалгасан.

Гурав. Иргэний зориг ногоон намын Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "... Үндэсний хорооноос зарласан намын ээлжит бус XIII Их хурлаас гарсан аливаа шийдвэр хууль бус бөгөөд хууль бус шийдвэрийн үндсэн дээр батлагдсан намын дүрмийн өөрчлөлт хууль ёсны болж чадахгүй тул хууль зөрчсөн Үндэсний хорооны шийдвэрийг үндэслэн гаргасан

аливаа шийдвэрийг шүүх хүлээн авах, бүртгэх боломжгүй учраас Б.Батбаатар нараас тус шүүхэд хүргүүлэх манай намын дүрмийн өөрчлөлтийг хүлээн авахаас татгалзаж өгнө үү” гэсэн хүсэлтийг; мөн Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатарын 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “... тус намын гишүүн Р.Батболд нам төлөөлөх эрхгүй бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр намын Онц Их хурал гэх дүрмийн бус үйл ажиллагаа зохион байгуулсан, тухайн үйл ажиллагаанд оролцсон хүмүүс эрхгүй этгээдүүд бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь намын дүрмийн 18.3, 21.1-д заасныг зөрчсөн, Онц Их хурал гэх хүчин төгөлдөр бус болох нь Дүрмийн хорооны шийдвэрээр тогтоогдсон, ... дүрмийн дагуу зохион байгуулж буй “Их хурал” хууль ёсоор төлөөлөх эрх бүхий намын дарга Б.Батбаатарт хадгалагдаж байгаа ...” гэсэн хүсэлтийг гаргасан, эдгээрийг нэгтгэсэн болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатарын ирүүлсэн “2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаар баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга)”-ийг бүртгэж, харин 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын ирүүлсэн “Намын даргаар сонгогдсоныг болон намын дүрмийн өөрчлөлт”-ийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “... нэг намаас нэг дүрэм бүртгүүлэхээр ирүүлсэн нэг өргөдлийг хүлээн авч хэлэлцэн, шийдвэрлэнэ” гэсэн үндэслэлээр Иргэний зориг ногоон намын дотоод маргаантай асуудлаа шийдвэрлэтэл, намын дүрмийн бүртгэлийг шийдвэрлэх хугацааг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл хойшлуулж шийдвэрлэсэн.

Өргөдөлд хавсаргасан баримтаас үзэхэд, энэ тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор талууд бие биедээ урилга, албан бичгээр уулзах санал хүргүүлж байсан, харин тус намын ахмадын хорооны даргын санаачилгаар 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Р.Батболд, М.Амартунгалаг, Б.Батбаатар, Я.Санжмятав, н.Алтан-Оч нар уулзсан байна.

Тус намын дотоод асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага болох Дүрмийн хороо нь 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, ДХ/05 дугаар тогтоолоор “... 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурал нэрээр зохион байгуулагдсан хурал нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй хүчин төгөлдөр дүрмийн 18.3, 18.4-т заасан Их хурлыг хуралдуулах журам, эрх бүхий байгууллагын шийдвэр, төлөөлөгчийн бүрдэл, ирцийн шаардлагыг хангаагүй тул намын дүрэмд нийцээгүй, хүчин төгөлдөр Их хуралд тооцогдохгүй болохыг, мөн уг хурлын төлөөллийн бүрдэл, санал хураалтын дүнг намын хүчин төгөлдөр дүрэмд нийцээгүй болохыг, Дүрмийн хорооны шийдвэрүүдийг хэвээр үлдээснийг, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намын дарга Б.Батбаатарын бүрэн эрх дуусгавар болоогүй, хэвээр хадгалагдаж байгааг, намын ээлжит бус XIII Их хурлаар баталсан намын дүрэм нь намын эрх бүхий

байгууллагын шийдвэрийн дагуу хэлэлцэгдсэн, намын дүрэмд нийцсэн хүчин төгөлдөр шийдвэр болох” тухай дүгнэжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн”, 5 дугаар зүйлийн 5.8-д “Төр иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэгтэй” гэж тус тус заасан, энэ тохиолдолд нэр бүхий гишүүд хоорондоо саналын зөрүүтэй, дотоод маргаантай байгаа нь тухайн намын шинэчилсэн дүрмийг бүртгэхгүй байх, улмаар намын гишүүний эвлэлдэн нэгдэх эрхийг хөндөх үндэслэл болохгүй. Иймээс Иргэний зориг ногоон намын гишүүдийн эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх, эрх ашгийг нь хангах зарчмын хүрээнд уг намын дүрмийн бүртгэлтэй холбоотой ирүүлсэн өргөдлүүдийг “намын дүрмийн дагуу хуралдсан” эсэхийг гол шалгуур болгон шийдвэрлэв.

Нэг. Намын ээлжит бус XIII Их хурлыг зарласан процессын тухайд:

Иргэний зориг ногоон намын дүрэм (2023 он)-ийн 18.1-д “Намын Удирдах дээд байгууллага нь “Улс төрийн намын тухай” хуульд заасны дагуу тус намын Их хурал байна”, 18.2-т “Их хурлыг 4 жил тутам зарлан хуралдуулна”, 18.3-т “Их хурлыг зарлан хуралдуулах тов түүнд оролцуулах төлөөлөгчийн тоог Үндэсний хороо тогтооно”, 19.1-д “Дараах асуудлыг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд: гээд 19.1.1-д “Намын дүрэм, намын мөрийн хөтөлбөрийг батлах”, 19.2-т “Их хуралд оролцох төлөөлөгчдийн 50%+1 нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно”, 19.3-т “Их хурлын хуралдааны дэгийг тухайн Их хурал өөрөө тогтооно”, 20.2-т “Үндэсний хороо 219 хүртэл гишүүнтэй байна”, 21.1-д “Үндэсний Хорооны ... хурлын товыг Улс төрийн Зөвлөл, намын дарга тогтоох ба хурал болохоос 7-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана ...”, 25.2-т “Улс төрийн зөвлөлийг Үндэсний хорооны гишүүдээс бүрдүүлэх ба 45 хүртэл гишүүнтэй байна ...”, 25.3-т “Улс төрийн зөвлөлийн хурлыг ... шаардлагатай гэж үзвэл намын дарга, ... ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзвэл, Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатарын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Улс төрийн зөвлөлийн хурал 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдсан, уг зөвлөлийн УТЗ/03-01 дүгээр тогтоолоор Үндэсний хороог 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зарлан хуралдуулсан, тус хуралд 2026 оны Үндэсний хорооны гишүүний татвараа төлсөн нийт 82 гишүүн оролцохоос 56 гишүүн буюу 68.2 хувьтай оролцсон, эдгээр гишүүдийн нэрсийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй намын хувийн хэргээс шалгахад, 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн намын Их хурлын ИХ-01/11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан 128 гишүүний нэрстэй тулгахад тохирч байх тул хуралд оролцох эрх бүхий этгээдүүд оролцсон байна.

Улмаар Үндэсний хорооны 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын ҮХХ/01-09 дүгээр тогтоолоор намын ээлжит бус XIII Их хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, төлөөлөгчдийн тоог 181 байхаар тогтоож, төлөөлөгчдийн квотыг хуваарилахыг намын ээлжит бус XIII Их хурлыг зохион байгуулах комисст даалгасан, уг комисс нь Үндэсний хорооны 82 гишүүн, нийслэлээс 9, есөн дүүрэг, хорин нэгэн аймгаас тус бүр 2, намын дэргэдэх байгууллагуудаас 30 төлөөлөгч сонгож ирүүлэхээр квот тогтоосны дагуу нийслэлийн намын хорооны хурал 9, Багануур, Багахангай, БГД, БЗД, Налайх, СБД, СХД, ХУД, ЧД-ээс 69, аймгуудаас 73, намын дэргэдэх байгууллагуудаас 30, нийт 181 төлөөлөгчийн нэрсийг баталж ирүүлжээ. Тухайн хурлын зарыг намын албан ёсны цахим хуудаст байршуулан, төлөөлөгч нарт утсаар болон мессеж (зурвас)-ээр мэдэгдсэн байна.

2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр танхимаар зохион байгуулсан намын ээлжит бус XIII Их хуралд 2026 оны намын гишүүний татвар төлсөн 134 гишүүн буюу 74.03 хувь нь оролцсон нь нэмэлтээр ирүүлсэн намын дансны 2024-2026 оны “Депозит дансны дэлгэрэнгүй хуулга”-аар тогтоогдож байх тул тухайн хурлыг хуралдуулсан процесс зөрчилгүй.

Тухайн намын дүрэм (2023 он)-ийн 7.1-д “Намын гишүүн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд: гээд 7.1.11-д “намын гишүүний болон сонгуульт гишүүний хувьд татвараа хугацаанд нь төлөх”, 9 дүгээр зүйлд “Намын гишүүн болон сонгуульт гишүүнд хариуцлага тооцох үндэслэл, журам”, 9.1.5-д “Сонгуульт гишүүний хувьд үүргээ зохих ёсоор биелүүлээгүйг нь Дүрмийн хороо тогтоосон бол түүнийг сонгуульт үүргээс нь чөлөөлөх”, 9.1.6-д “Сонгуульт гишүүн тухайн жилийн татвараа 2 дугаар сарын 1-нд, 8 дугаар сарын 1-ний дотор төлнө. Төлөөгүй тохиолдолд сонгуульт гишүүний эрх дуусгавар болж нөхөн сонгуульт зарлагдана”, 9.2-т “Намын төв болон дунд шатны байгууллагаас өөрт харьяалагдах гишүүнд Үндсэн дүрмийн 9.1 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцно” 10.1-д “Намын хариуцлага дараах хэлбэртэй байна. Үүнд:”, 10.1.1-д “Сонгуульт эрхийг нь цуцлах”, 20.7-д “Үндэсний хорооны гишүүний бүрэн эрх дараах үндэслэлээр дуусгавар болно. Үүнд: гээд 20.7.3-т “Намын дүрмийн 10.1.1, 10.1.3-т заасан хариуцлага хүлээснээр”, 20.9-д “Энэ дүрмийн 20.7.2-20.7.4-т заасан үндэслэлээр бүрэн эрх нь дуусгавар болсон Үндэсний хорооны гишүүний оронд шинээр гишүүн сонгоно” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн “ИЗНН-ын сонгуульт гишүүдийн 2026 оны татвар төлөлтийн мэдээ, лавлагаа” гэсэн баримтаар Улс төрийн зөвлөл болон Үндэсний хорооны татвар төлсөн гишүүдийн нэрсийг гаргасан, мөн Дүрмийн хорооны 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Үндэсний хорооны зарим сонгуульт гишүүдийн эрх дуусгавар болсон тухай” ДМ/11, Улс төрийн зөвлөлийн зарим сонгуульт гишүүдийн эрх дуусгавар болсон тухай” ДМ/12 дугаар шийдвэрээр татвар төлөөгүй гишүүдийг “намын дүрмийн 7.1.11, 9.1.5, 9.1.6, 32.2, 32.4.1, 32.4.3, 32.4.4, 32.4.9 дэх заалтуудыг баримтлан, ... 2025 оноос бүрэн эрх нь хэрэгжиж байсан Үндэсний хорооны нийт 128 сонгуульт гишүүнээс 43 гишүүн нь сонгуульт гишүүний татвараа дүрэмд заасан хугацаанд төлөөгүй, Улс төрийн зөвлөлийн нийт 37 сонгуульт гишүүнээс 15 гишүүн нь сонгуульт гишүүний татвараа дүрэмд заасан хугацаанд

төлөөгүй тул сонгуульт гишүүний эрх 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс дуусгавар болсон” гэж үзжээ.

Үүнээс үзэхэд, намын дүрэм, дотоод зохион байгуулалтад хяналт тавих чиг үүргийнхээ дагуу Дүрмийн хороо нь 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ДМ/11, “Улс төрийн зөвлөлийн зарим сонгуульт гишүүдийн эрх дуусгавар болсон тухай” ДМ/12 дугаар шийдвэрээр Үндэсний хорооны 82, Улс төрийн зөвлөлийн 22 сонгуульт гишүүний эрх 2026 онд хэвээр хадгалагдаж байгааг тэмдэглэж, сонгуульт гишүүний эрх дуусгавар болсонтой холбоотой аливаа өргөдөл, гомдол ирүүлээгүй талаар дурдсан, Дүрмийн хорооны 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн ДХ/05 дугаар тогтоолоор тухайн шийдвэрийг хянасан зэргээс үзэхэд, Иргэний зориг ногоон намын Үндэсний хороо, Улс төрийн зөвлөл, намын ээлжит бус XIII Их хурлын ирцийг татвар төлсөн гишүүдээс бүрдүүлж, тооцсон нь намын дүрэмд нийцсэн байна.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд хууль хэрэгжихээс өмнө Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Улс төрийн намын тухай (2005 оны) хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг баримтлан Иргэний зориг ногоон намын Үндэсний хорооны ээлжит хурлын 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг” улсын бүртгэлд бүртгэсэн, энэхүү намын дүрэм өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр байна.

Иргэний зориг ногоон намын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболд нь сонсох ажиллагааны явцад болон шүүхэд ирүүлсэн тайлбартаа “... намын 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Үндэсний хороо”-ны ээлжит хурлаараа Үндэсний зөвлөлийн хорооны гишүүд гэж 128 гишүүдийг баталсан нь намын дүрмийн 19.1.4-т заасныг зөрчиж Их хурлын бүрэн эрхэд халдсан, Монгол Улсын дээд шүүхэд бүртгэгдээгүй тус дүрэмд төлөөллийн төв байгууллагыг “Үндэсний зөвлөлийн хороо” гэж нэрийг өөрчлөн намын дүрэмд байхгүй байгууллагыг хуралдуулсан, ... 128 гишүүд нь намын төлөөллийн төв байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжгүй ...” гэжээ.

2005 оны Улс төрийн намын тухай хуулийн 13.2.2-т “намын төлөөллийн төв болон хяналтын төв байгууллагын тайланг хэлэлцэх, тэдгээрийн бүрэлдэхүүнийг сонгох”-ыг Их хурал хэлэлцэн шийдвэрлэх, харин 13.4-т “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж, тухайн 2023 оны Иргэний зориг ногоон намын дүрмийн 2.2.3-т “Намын орон нутгийн удирдах байгууллага болон төлөөллийн төв байгууллага түүнчлэн намын удирдах төв байгууллагын бүрэлдэхүүнийг дүрэмд заасны дагуу шинэчлэн сэлбэж (ротаци) байх” зарчмыг баримтлах, 19.1.4-т “Үндэсний хороог сонгож байгуулах, ...” -ыг Их хурал хэлэлцэн шийдвэрлэх, харин Үндэсний хороо нь 22.1.2-т “Үндэсний Хорооны гишүүн орон гарах тохиолдолд түүний оронд санал болгосон гишүүнийг хэлэлцэж шийдвэрлэх”-ээр заасан байна.

Тус зохицуулалтын дагуу Иргэний зориг ногоон намын Үндэсний зөвлөлийн хорооны 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн ҮЗХ-01/01 дүгээр тогтоол, мөн XI Их хурлын 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үндэсний зөвлөлийн хорооны гишүүдийг батлах тухай” ИХ-01/11 дүгээр тогтоол тус тус авагдсан, дээрх тогтоолуудаар Үндэсний зөвлөлийн хорооны 128 гишүүний нэрсийг баталжээ.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 03 дугаар 28-ны өдрийн 17 дугаар тогтоолоор намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэхдээ “... Улсын дээд шүүхэд бүртгэгдээгүй тус намын дүрэмд төлөөллийн төв байгууллагыг “Үндэсний Зөвлөлийн Хороо” гэж нэрийг өөрчилж, улмаар тус хороо 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, намын дүрмийн өөрчлөлтийг баталсан нь намын дүрмийн дээрх заалтад нийцэхгүй байна ...” гэж, мөн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолд “... энэхүү ирүүлсэн намын даргыг бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримтад “Үндэсний зөвлөлийн хороо 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, ҮЗХ-01/06 дугаар тогтоолоор намын XI Их хурлыг 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хуралдуулахаар товлон зарлаж, төлөөлөгчдийн тоог ҮЗХ-ны гишүүдийг оруулж нийт 450 хүн оролцохоор баталсан” гэсэн нь тус намын хүчин төгөлдөр бүртгэлтэй байгаа дүрэмтэй зөрчилдсөн гэж үзэхээр байна. Иймд төлөөллийн төв байгууллага болох Үндэсний хорооноос гаргаагүй нь намын дүрмийн 18.3-т нийцээгүйг анхаарах шаардлагатай, ... Иргэний зориг ногоон намын Үндэсний зөвлөлийн хороо, Дүрмийн хорооны гишүүдийг сонгосон тогтоолыг Улсын дээд шүүх бүртгэхгүй болно ...” гэж тус тус дүгнэсэн байна.

Эдгээрээс үзэхэд, тухайн намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний хорооны нэрийг “Үндэсний зөвлөлийн хороо” гэж нэршлийн хувьд буруу тодорхойлсон байх хэдий ч шүүхээс тухайн байгууллагыг эрх зүйн хувьд чадамжгүй, 128 гишүүнийг сонгосон тогтоолыг хүчингүй гэж дүгнээгүй байна. Энэхүү тогтоолуудыг гарах үед тус намын нэр бүхий гишүүдийн зүгээс 128 гишүүнийг сонгосон төлөөллийн төв байгууллагын нэршилтэй холбогдуулан маргаж байгаагүй, хавсралтаар баталсан нэрсийн жагсаалтад тухайн гишүүдийн нэрс бичигдсэн, 2024 оноос эхлэн сонгуульт гишүүний татварыг (бүрэн, хагас) төлсөн гишүүдийг оролцуулан бүтцийн байгууллагын хурлууд зохион байгуулагдаж байсан байна. Мөн Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатарын ирүүлсэн 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/23 дугаар албан бичгийн 6 дугаар хавсралтад “2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар татвараа төлж сонгогдож, батлагдсан доорх хүснэгтэд дурдсан 32 гишүүнийг Үндэсний хорооны гишүүнээр нэмж, 128 гишүүнтэй болсон, 2025 оны XI дүгээр Их хурлаар эдгээр 128 Үндэсний хорооны гишүүдийг дахин баталгаажуулав” гэжээ.

Иймээс, Иргэний зориг ногоон намын дүрэм (2023 он)-ийн 20.2-т “Үндэсний хороо 219 хүртэл гишүүнтэй байна”, 25.2-т “Улс төрийн зөвлөлийг ... 45 хүртэл гишүүнтэй байна” гэж сонгуульт гишүүдийн тоог “хүртэл” гэж тодорхой тоог заагаагүй байх тул намын Үндэсний хорооны 128 гишүүнээс татвар төлсөн 82 гишүүн оролцохоос 56 гишүүн оролцсон, намын ээлжит бус XIII Их хурлыг 181 гишүүнээс

татвар төлсөн 134 гишүүн оролцож хуралдсан нөхцөл байдлыг процессын хувьд намын дүрмийг зөрчсөн гэж үзэхгүй.

Иймд, Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын "... Үндэсний хороо 128 төлөөлөгчтэй байсан ба ... 65 төлөөлөгчийг хуралдуулж Үндэсний хорооны гишүүнээр татвар шинээр төлсөн гишүүдийг батламжлалгүй шууд хурлын ирцэд оруулан бүртгэсэн нь хурлын ирц хүрээгүй, хүчин төгөлдөр бус ..." гэх тайлбарыг хүлээн авах, улмаар Улс төрийн намын тухай хууль болон намын дүрмийн аль нэг заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатар нь 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн өргөдөлдөө "Намын 2026 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Үндэсний чуулган нь намын хүчин төгөлдөр дүрмийн 7.1.4-т заасан гишүүдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх эрхийн хүрээнд зохион байгуулагдсан зөвлөлдөх нийтийн арга хэмжээ бөгөөд намын гишүүд ээлжит бус XIII дугаар Их Хурлыг хүчин төгөлдөр намын дүрмийн дагуу зохион байгуулагдсан болохыг дүгнэж, бүртгэлтэй дүрэм, удирдлагыг дэмжсэн байр сууриа илэрхийлж, Улсын дээд шүүхийн 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр намын зүгээс санаачилга гарган ажилласныг харуулна" гэж дурджээ.

Хоёр. Намын Онц Их хурал зарласан тухайд:

Иргэний зориг ногоон намын дүрэм (2023 он)-ийн 27.1-д "... Намын дарга, дэд дарга нар, Ерөнхий нарийн бичгийн дарга, Нийслэлийн намын хорооны дарга гэсэн албан тушаалтныг "Намын удирдлага" гэж томъёолно гэж заасан.

Аймаг, нийслэл, дүүргийн 11 намын хорооны дарга нараас Онц Их хурлыг зарлан хуралдуулах шаардлагыг намын Удирдлагад хүргүүлсэн, 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр тухайн намын Удирдлага 8 хүний бүрэлдэхүүнтэй хуралдаж, 26/УХ-01 дүгээр шийдвэрээр намын Онц Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зарлан хуралдуулахаар шийдвэрлэж, уг хуралд оролцох төлөөлөгчдийн тоог 450 байхаар тогтоожээ.

Удирдлагуудын хурлын болон ирцийн тэмдэглэлээс үзэхэд, тус хуралд УИХ-ын гишүүн Р.Батболд, дэд дарга С.Батбаатар, Т.Бат-Эрдэнэ, нийслэлийн намын хорооны дарга М.Амартунгалаг, тус хорооны дэд дарга Д.Дэжидмаа, намын даргын зөвлөх Д.Амгалан, Дүрмийн хорооны гишүүн П.Ууганболор, Улс төрийн зөвлөлийн гишүүн Ц.Энхжин оролцсон байна. Үүнээс УИХ-ын гишүүн Р.Батболд, намын даргын зөвлөх Д.Амгалан, Дүрмийн хорооны гишүүн П.Ууганболор, Улс төрийн зөвлөлийн гишүүн Ц.Энхжин, нийслэлийн намын хорооны дэд дарга Д.Дэжидмаа (эрх сэргэсэн баримтыг ирүүлсэн) нар нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй хүчин төгөлдөр дүрэмд зааснаар намын Удирдлагад хамаарахгүй байна.

Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболд нь 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн тайлбартаа "... намын удирдлагуудын 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хурлын бүрэлдэхүүнд оролцсон (Тэргүүн) дэд дарга С.Батбаатар, Т.Бат-Эрдэнэ, Я.Пүрэвгарьд, нийслэлийн намын хорооны дарга

М.Амартунгалаг нар нь дүрмийн 27.1-д заасантай нийцэж байна. Удирдлагын өргөтгөсөн дээрх хуралдаанд УИХ-ын гишүүн Р.Батболд, С.Замира (баримтжуулсан фото зурагт 8 хүний нэг нь УИХ-ын гишүүн С.Замира), намын даргын зөвлөх Д.Амгалан, Дүрмийн хорооны гишүүн П.Ууганболор, Улс төрийн зөвлөлийн гишүүн Ц.Энхжин, нийслэлийн намын хорооны дэд дарга Д.Дэжидмаа оролцож ... нийслэл, аймаг, дүүргийн 11 намын хорооны даргаас ирүүлсэн шаардлагыг хэлэлцсэн шийдвэрийг дэмжин оролцож санал хүсэлтээ илэрхийлэх нь дүрэм болон бусад эрх зүйн актаар хориглогдоогүй болно” гэсэн нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тус намын дүрэмд нийцээгүй байна.

Өргөдөлд хавсаргасан баримт, мөн тайлбарт дурдсан Удирдлагуудын хуралд оролцсон гишүүдийн нэрс нь өөр хоорондоо зөрүүтэй байхаас гадна, намын дүрмийн 18.1-д “Намын удирдах дээд байгууллага нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу тус намын Их хурал байна”, 18.3-т “Их хурлыг зарлан хуралдуулах тов түүнд оролцох төлөөлөгчдийн тоог Үндэсний хороо тогтооно” гэж Их хурлыг зарлан хуралдуулах тов, түүнд оролцох төлөөлөгчдийн тоог тогтоох эрхийг Үндэсний хороо хэрэгжүүлэх атал хурал зарлах эрхгүй этгээд болох намын Удирдлагуудын хурлаас Онц Их хурлыг зарлан хуралдуулсан нь зөрчилтэй, намын Удирдлагын шийдвэрийг үндэслэн Онц Их хурлыг зарлан хуралдуулсан гэх ажиллагаа нь намын дүрмийн 18.1, 18.3-т заасантай нийцэхгүй.

Нэгэнт намын дүрэмд заасан журмын дагуу эрх бүхий этгээдээс хурлыг зарлаагүй тул Онц Их хурал хүчин төгөлдөр бус, процессын зөрчилтэй байх учир намын даргаар Р.Батболд сонгогдсон болон уг хурлаас баталсан намын дүрмийн өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийг зөрчиж байна.

Р.Батболдоос 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа “... гишүүдийн татвар, хандив, төрөөс парламентад суудалтай намуудад олгосон санхүүжилтийг хууль бусаар захиран зарцуулсан, Авлигатай тэмцэх газраас хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаа, Сонгуулийн ерөнхий хорооны дотоод болон хөндлөнгийн аудитын дүгнэлтүүдээр нийт 378,684.2 мянган төгрөгийн зөрчил илэрч худалдан авах ажиллагааны гэрээ байгуулаагүй, зориулалтын бус, хувьдаа захиран зарцуулсан гэх мэт үндэслэл бүхий актууд гарсан ...” гэсэн, уг асуудал нь намын Онц Их хурал зарлах үндэслэл болох талаар тус намын дүрэмд заагаагүй, нөгөө талаар гэм буруутайг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа намын дүрмийн дагуу уг асуудлыг шийдвэрлэхээр байна.

Мөн 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр “... татвар төлсөн гишүүний талаарх хувийг Б.Батбаатараас ирүүлсэн дансны хуулгаар тодорхойлсон нь Онц Их хурлын төлөөлөгч, намын гишүүд, дэмжигчдийн оролцоо, сонгох сонгогдох эрхийг хязгаарлах дүгнэх боломжгүй, ... намын гишүүд өөрсдийн хүсэл зоригийн үндсэн дээр гишүүдийн “Онц Их хурал”-д оролцсон нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуульд заасан эрхээ эдэлсэн, мөн намын дүрмийн 4.1, 4.3-т зааснаар тухайн Онц Их хуралд оролцсон гишүүд дэмжигчдийг үгүйсгэх үндэслэлгүй” гэсэн тайлбарыг ирүүлсэн боловч намын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт нь бүртгэлтэй, хүчин төгөлдөр үйлчилж байгаа намын дүрмийн

дагуу явагдах ёстой, тодруулбал намын дүрэм батлах, намын даргыг сонгох зэргээр шийдвэр гаргах ажиллагаа нь тодорхой шалгуур, дэгтэй, уг шалгуурыг хангаагүй бол хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн гэж үзэх боломжгүй, ээлжит бус Их хурал зарлах эрхтэй субъект болох Үндэсний хороонд хүсэлтээ гаргаж байгаагүй, намын дүрэмдээ гишүүн татвараа төлөөгүй бол сонгуульт гишүүний эрх нь дуусахаар заасан, намын дэмжигчийн хувьд саналын эрхгүй тул дээрх тайлбар үгүйсгэгдэнэ.

Иргэний зориг ногоон намын дүрэм (2023 он)-ийн 18.2-т “Их хурлыг 4 жил тутам зарлан хуралдуулна”, 28.3-т “Намын даргын бүрэн эрх дараагийн дарга сонгогдсоноор дуусгавар болно” гэжээ. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Иргэний зориг ногоон намын даргаар Б.Батбаатарыг бүртгэсэн, уг бүртгэл хүчин төгөлдөр байна. Тодруулбал, Иргэний зориг ногоон нам нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилсэн Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн дагуу “намын даргыг сонгож, бүрэн эрхийг 4 жилийн хугацаагаар баталсныг бүртгүүлэх” өргөдлийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр гаргасныг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолоор “Улсын дээд шүүхэд бүртгэгдээгүй намын дүрмийн дагуу намын даргыг сонгож ирүүлсэн нь Улс төрийн намын тухай хуульд нийцээгүй, ... хуулийн дагуу дүрмээ батлах, уг дүрэм болон хуульд нийцүүлэн намын даргыг сонгох ажиллагааг хийж, улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлөө нэг мөр ирүүлэх нь зүйтэй” гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Ийнхүү тус намын даргын асуудлыг шинэчлэн бүртгэхээс татгалзсан нь өмнөх намын даргаар Б.Батбаатарыг бүртгэсэн 2023 оны бүртгэлийг үгүйсгэсэн үр дагавар үүсгэхгүй тул “... Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 26 дугаар тогтоолоор намын даргыг бүртгэхээс татгалзсан нь намын даргын эрх зүйн байдал тодорхойгүй, чадамжгүй нөхцөл байдал үүссэн” гэх Р.Батболдын тайлбар үндэслэлгүй.

Дээрх үндэслэлээр Иргэний зориг ногоон намын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын ирүүлсэн “Онц Их хурлаас намын даргаар сонгогдсоныг болон намын дүрмийн өөрчлөлт”-ийг бүртгэхээс татгалзав.

Гурав. Намын ээлжит бус XIII Их хурлаас баталсан намын дүрэм хуульд нийцсэн тухайд:

Иргэний зориг ногоон намаас өмнө нь дүрмийн өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд нийт 4 удаа хандсан, тухайлбал Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 35 дугаар тогтоолоор “Үндэсний хорооны хурлын үйл ажиллагаа намын дүрэмд нийцээгүй, намын дүрэм нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй гээд 4 үндэслэл бүхий 18 зөрчлийг дурдаж”, 2025 оны 17 дугаар тогтоолоор “хурал зарласан үйл ажиллагаа нь намын дүрэмд нийцээгүй, дүрмийн өөрчлөлт нь гуравны нэгээс хэтэрсэн, мөн 3 зөрчил болон дугаарлалтын алдааг дурдаж” намын дүрмийг

тус тус бүртгэхээс татгалзсан бол Улсын дээд шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 02/3497 дугаар албан бичгээр 7 үндэслэл бүхий 25 зөрчлийг дурдаж, өргөдлийг буцааж шийдвэрлэсэн.

Мөн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор намын дүрмийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэхдээ "... Иргэний зориг ногоон намын Их хурал нь төлөөллийн төв байгууллага болох Үндэсний Зөвлөлийн Хорооны бүрэлдэхүүнийг сонгох, эсхүл батламжлах зарчмыг хэрэгжүүлж, харин орон гарсан тохиолдолд гишүүнийг бүрэн эрхийг нөхөн "батламжлах" эрхийг Үндэсний Зөвлөлийн Хороо нь өөртөө олгохоор шийдвэрлэсэн нь хуулийн 17.2.2-т заасантай нийцэхгүй; ... хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох Их хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах эрхийг Үндэсний Зөвлөлийн Хороонд шилжүүлсэн нь буруу, Дүрмийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд санал болгох субъект нь тодорхойгүй; ... дүрмийн 12.2-т "... Хурлын дэгээр саналыг нууцаар хураахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд илээр хураана" гэж заасан нь ойлгомжгүй. Учир нь намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагыг байгуулахдаа нууц санал хураалт явуулах буюу дээрх хуульд заасан шаардлагад нийцсэн гэж үзэх үндэслэлгүй тул тодруулах шаардлагатай ..." гэсэн 3 зөрчлийн талаар дурдсан алдаа зөрчлийг зассан байна.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна", 15.2-т "Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана" гээд 15.2.1-15.2.10-т намын дүрэмд тавигдах шаардлагыг тодорхойлсон. Тухайлбал,

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан "намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл"-ийг намын дүрмийн 6 дугаар зүйлд намд гишүүн элсүүлэх журам, 7 дугаар зүйлд намын гишүүний эрх, үүрэг, 9 дүгээр зүйлд намын гишүүн болон сонгуульт гишүүнд хариуцлага тооцох үндэслэл, 10 дугаар зүйлд намын гишүүн, сонгуульт гишүүнд хүлээлгэх хариуцлагын төрөл зэрэг зохицуулалтыг заасан байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т "намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам" гэж заасан.

Намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийн 12.1-д "Намын Удирдах дээд байгууллага нь намын "Их Хурал", Төлөөллийн төв байгууллага нь "Үндэсний Зөвлөлдөх Хороо", 12.2-т "Намын ээлжит ИХ-ыг дөрвөн жилд нэгээс доошгүй хуралдуулна", 13.2-т "ИХ-д оролцох нийт төлөөлөгчдийн олонх нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ... асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ", 12.4-т "ҮЗХ нь намын ИХ хуралдах тов, төлөөлөгчдийн тоог тогтооно", 14.2-т "ҮЗХ 183 гишүүнтэй байна", 17.2-т "УТЗ-ийг ҮЗХ-ны гишүүдээс бүрдүүлэх ба 45 гишүүнтэй байна ...", 30.1-д "Намын хяналтын байгууллага нь Хяналтын төв байгууллага болох

“Дүрмийн хороо ...”, 31.2-т “Дүрмийн хороо нь 9 гишүүнтэй байх ...”, 32.1-д “Дүрмийн хорооны хурлыг шаардлагатай асуудлаар хэдийд ч зарлан хуралдуулж болно ...”, 32.3-т “Дүрмийн хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэр гаргана” гэж эдгээр байгууллагыг хуралдуулах, хурлын тов тогтоох, зар мэдэгдэх, хурал хүчин төгөлдөр болох нөхцөл, шийдвэр гаргах, санал хураалтын журам, мөн тус хурлын бүрэлдэхүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох болон бүрэлдэхүүнийг чөлөөлөх, огцруулах үндэслэл журмын талаар тус тус зохицуулжээ.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмийн 27.1-д “Нам нь намын даргатай байна. Намын даргын эрх, үүрэг энэ дүрэмд зааснаар тодорхойлогдоно”, 27.3-т “Намын даргад нэр дэвшигчийг энэхүү дүрмийн 27.4-т заасан журмаар нэр дэвшүүлж болно”, 27.4.1-д “Намын даргад нэр дэвших намын гишүүдийг намын ХЭГ-аас бүртгэх, баримт бичиг хүлээн авах, дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж ИХ-д танилцуулна. Үүнд” гээд 27.4.1.1-27.4.1.5 дэх заалтад тавигдах шаардлагыг, 27.5-д “Намын ИХ-аар намын даргад нэр дэвшигчдээс нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг намын даргаар 4 жилийн хугацаатай сонгоно”, 28 дугаар зүйлд намын дарга түүний эрх, үүрэг, 28.3-т “Нам нь УИХ-ын сонгуульд өмнөх сонгуулийн амжилтаасаа ухарч, УИХ дахь суудлын тоо үлэмж хэмжээгээр буурсан үндэслэлээр ҮЗХ-ны нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал оруулсан бол ҮЗХ хуралдаж, Намын даргыг огцруулах эсэхээр санал хураан, олонхын саналаар дэмжсэн тохиолдолд Намын даргыг огцруулах болон Намын даргыг шинээр сонгох асуудлаар ээлжит бус ИХ-ыг зарлана. ҮЗХ-ны гишүүдийн олонх дэмжээгүй бол тухайн бүрэн эрхийн хугацаанд дахин огцруулах асуудлыг хэлэлцэхгүй”, 28.4-т “Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон, бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, тохиолдолд ээлжит бус ИХ-ыг зарлан хуралдуулж шийдвэрлүүлнэ” гэж намын даргад нэр дэвших, сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ талаар ерөнхийлөн зохицуулсан.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д заасан “намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг дүрмийн 33.1-д “Намын орлого дараах эх үүсвэртэй байна. Үүнд” гээд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого, Улс төрийн намын тухай хуулиар зөвшөөрсөн бусад орлого зэргээс бүрдэхээр зохицуулсан байна. Мөн дүрмийн 34.1.1-34.1.5 дахь заалтуудад төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийн талаар тусгажээ.

Дээрх байдлаас дүгнэвэл, Иргэний зориг ногоон намын 2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлын ИХ/13-06 дугаар тогтоолоор баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга) нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байх тул бүртгэхээр тогтов.

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсгийг баримтлан Иргэний зориг ногоон намын дарга Б.Батбаатарын ирүүлсэн “Иргэний зориг ногоон намын 2026 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлын ИХ/13-06 дугаар тогтоолоор баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга)”-ийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5, 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийг баримтлан Иргэний зориг ногоон намын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Онц Их хурлаас сонгогдсон намын дарга гэх Р.Батболдын ирүүлсэн “Иргэний зориг ногоон намын даргаар Р.Батболд сонгогдсоныг болон намын дүрмийн өөрчлөлт”-ийг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ